



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГА Э.БАТТУЛГА ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.25 № 788
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Цаг уур, орчны шинжилгээний газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Бүгд Найрамдах Солонгос улсын Байгаль орчны яам, Байгаль орчны корпораци хоорондын гэрээ хэлэлцээрийн үр дүнд “Монгол улсад агаарын чанарын автомат станцыг байгуулж, агаарын чанарын менежментийн чадавхыг сайжруулах”-аар буцалтгүй тусламжаар нийслэл, 21 аймгийн төвд мэдээллийн технологид суурилсан орчны агаарын чанарыг хянах автомат станцыг суурилуулах, чадавхыг бэхжүүлэхэд зориулж нийт 8,914.7 мянган ам.долларын хөрөнгийг шийдвэрлэж, хэрэгжүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн газар болон НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр хамтран хэрэгжүүлсэн “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавх болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” (АДАПТ) төслийн хүрээнд ус цаг уур, орчны шинжилгээний салбарт 1,500.0 мянган ам.долларын үнэ бүхий шинэ үеийн супер компьютерын технологийг нэвтрүүлж, уур амьсгал, цаг агаарын тооцоолол, урьдчилсан мэдээний нарийвчлалыг сайжруулан, цаг агаарын гамшгийг эрт илрүүлэх, сэрэмжлүүлэх, урьдчилан мэдээлэх боломжийг нэмэгдүүлж, бэлэн байдлыг хангах, шуурхай хариу арга хэмжээ авах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Цаг уур, орчны шинжилгээний газрын инженерүүд нь цаг уурын автомат станцын мэдээг шуурхай хүлээн авах зорилго бүхий шөнийн хугацааны 23, 02, 05 цагийн мэдээг автоматаар хүний оролцоогүй кодолж, урьдчилан мэдээлэх шуурхай үйл ажиллагаанд ашиглах, олон улсын мэдээ солилцоонд гаргах "Overnight Weather Lookout" буюу "Шөнийн хугацааны цаг агаарыг ажиглагч" нэртэй программ хангамжийг бүтээж, үйлдвэрлэлд нэвтрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны А/237 дугаар тушаалаар "Цаг уурын салбарын орон нутаг дахь өртөөний байр"-ыг нийслэлийн 2 дүүрэг, 14 аймагт, нийт 20 өртөөг 5,624.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, тайлант онд барьж ашиглалтад оруулахаар 4 бүсээр багцлан эрх шилжүүлсэн боловч гүйцэтгэлээр 2 өртөөний 558.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон, хөрөнгө оруулалтын ажлын хэрэгжилт хангалтгүй байна.

Бусад асуудал

Төрийн аудитын байгууллага нь төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудитыг хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартын дагуу хууль, тогтоомжийн хэрэгжилтэд нэмэлт горим сорил гүйцэтгэх үүрэг хүлээдэг.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



С.МАГНАЙСҮРЭН